

**ДАРХАН-УУЛ АЙМАГ, “ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ТӨХК-ИЙН  
ТӨМӨРТОЛГОЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2025 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-010738/

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2051303/

## АГУУЛГА

1. ТӨМӨРТОЛГОЙН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА .....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	7
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	7
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	7
3.3. Газар болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	7
3.4. Ургамлан нөмрөгийн чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	8
3.5 Амьтны аймаг, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	8
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	9
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	10
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ....	10
5.2. Гадаргын ба газрын доорх усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	11
5.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	12
5.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..	13
5.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	13
5.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө .....	14
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
8. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	18
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
15. НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
16. ТӨМӨРТОЛГОЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2025 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ .....	21

## 1. ТӨМӨРТОЛГОЙН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА

**Ерөнхий мэдээлэл:** “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ийн 10738А тоот тусгай зөвшөөрөл бүхий Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт 2009 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Манай уурхай нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөндөө уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖЯ-ны төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд (2024.03.12-ны № 12/1114) туссан болзошгүй болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллаж байна.

**Ашиглалтын талбай:** 424.09 га.

**Нөөц:** Төмөртолгойн уурхайг анх 2009 оноос эхлэн ордын төв болон зүүн биетийг ашиглаж эхэлсэн бөгөөд 2014 онд төв, 2020 онд зүүн биетүүдийн хүдрийн нөөцийг бүрэн олборлож дууссан байна. Ордын баруун биетэд 2014-2015 онд нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэж 2017 оны 01-р сарын 01-ны өдрийн байдлаар 9.9 сая тонн нөөц тогтоон улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байдаг. Баруун биетийн хүдрийн олборлолтыг 2019 оноос эхлүүлсэн байдаг бөгөөд 2023 оны 01-р сарын 01-ны өдрийн байдлаар баруун биетэд 4.9 сая тонн геологийн нөөцийн үлдэгдэлтэй байна. 2016 онд Төмөртолгойн уурхайд одоогийн хуурай соронзон баяжуулах үйлдвэр 1-ийг барьж ашиглалтад оруулан төмрийн өндөр агуулгатай хуурай баяжмалыг үйлдвэрлэн экспортолж эхэлсэн.

**Байршил:** Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс 28 км, Хонгор сумаас зүүн тийш 17 км зайтай байрлана. Тус ордод 2009 оноос төмрийн хүдэр олборлон хуурай соронзон аргаар баяжуулалт хийгдэж төмрийн баяжмал боловсруулан гаргаж байна.

Ордын талбайн захын цэгийн солбилцол /WGS - 84/:

№	Зүүн уртраг	Хойд өргөрөг
1	106° 09' 42.21"	49° 18' 41.91"
2	106° 11' 22.21"	49° 18' 41.90"
3	106° 11' 42.21"	49° 17' 33.91"
4	106° 09' 42.21"	49° 17' 33.91"

**Зам харилцаа:** “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-иас Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхайн хооронд 28 км сайжруулсан шороон замыг 2011 онд ашиглалтанд оруулан ашиглаж байна. Тус замын арчилгааг байнга өөрийн тоног төхөөрөмжөөр засварладаг. Энэхүү замыг ашиглалтад оруулснаар Шарын гол болон Хонгор сумдын иргэд зорчихдоо газрын хөрсийг эвдэх, өөрсдийн дураар шинэ зам гаргах зэрэг байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагааг таслан зогсоосон.

**Боловсон хүчин:** Одоогоор Төмөртолгойн уурхай нь 6 хэсэг, 3 алба, 1 хэлтэс бүхий нийт 428 ажиллагсадтайгаар, өдрийн болон ээлжийн буюу ростерийн системийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

**Цахилгаан хангамж:** Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах 35 кВ-ын төвийн агаарын эрчим хүчний шугамаас 17.4 км ЦДАШ салбарлуулан 6.3 мВа чадалтай 35/6 кВ-ын бууруулах дэд станцаар Төмөртолгойн уурхайн нийт эрчим хүчний хэрэглээг хангадаг.

**Усны хэрэгцээ:** Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхай нь үндсэн 3-н гол усны хэрэглэгчидтэй ба дараах хэрэглэгчид орно. Үүнд:

- Унд, ахуйн хэрэглээний ус
- Зам талбайн усалгаа
- Байгаль орчин зэрэг багтана.

**Унд, ахуйн хэрэглээний ус:** Цэвэр усны гүний худагтай. Уурхай дээр байгаа ажилчдын хоол цай, унд ахуйн хэрэглээ болон цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэнэ. Ундны усыг уурхайд байрлах худгаас машинаар зөөвөрлөн авч ашигладаг.

**Зам талбайн усалгаа:** Төмөртолгой уурхайн тоосжилтыг дарах зорилгоор гадаад болон дотоод авто зам талбайн усалгаанд 15 тн-н HOWO 336 загварын зориулалтын тоногдсон усны машин ашигладаг. Усыг шүүрлийн усан сангаас авна.

**Байгаль орчны усны хэрэглээ:** “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны усалгаанд шаардлагатай усыг шүүрлийн усан сангаас авна

**Дулаан хангамж:** Уурхайн цайны газар, эмнэлэг, засварын газар, оффис, ахуйн байр, баяжуулах үйлдвэрийн ажлын байр болон операторын өрөөнүүдэд цахилгаан ялтсан бойлууран халаалт, хуурай тень, усан тень ашигладаг.

- Уурхайн цайны газар цахилгаан дакон халаалт
- Засварын газрын халаалт нь ялтсан бойлууран цахилгаан тосолоор хосолсон халаалттай
- Засварын 2 давхрын халаалт нь даконы цахилгаан халаалттай
- Уурхайн бүх ажлын байр сууцанд бүх хэсэгт цахилгаан халаалт буюу усан тень халаагууртай байна.

## **2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**Уур амьсгал:** Аймгийн нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай тэгэхдээ өргөргийн хувьд арай хойгуур оршдог хийгээд нутгийн ихэнхэд нь уул хөндийг дагасан том жижиг гол горхины хөндий салбарлаж бас голын ай сав нь үлэмж өндөрт орших тул уур амьсгалын өндрийн ялгаа гарна. Дархан хотод байрлах цаг уурын харуулын 2018-2023 оны сар бүрийн дунджаас харахад хамгийн хүйтэн нь 12-1 сард -14-22.8 градус хүрдэг бол дулааны улирал нь 6-8 сард 16.6-21.2 градус хүрнэ. Дархан-Уул аймгийн хувьд тухайн районд 2018-2024 оны цаг уурын ажиглалтын мэдээгээр сарын нийлбэр хур тунадасны эзлэх хувь нь дулааны улиралд буюу 6-8 саруудад зун, намрын улиралд 92-97%-ийг эзэлж байна. Хүйтний саруудад буюу 11-4 сард нийт тунадасны 2-7% унадаг.

**Агаарын чанар:** Төмөртолгойн уурхайн үйл ажиллагааны үед агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх үүсвэр нь ил уурхайн олборлох болон хүдэр баяжуулах үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт байна. "Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланд Төмөртолгойн уурхайн агаарын чанарт нөлөөлөх байдлыг 150 м зайд стандарт (0.5мг/м<sup>3</sup>) -аас аль ч улиралд давж агаарын чанарт нөлөөлөх нөхцөлтэй гэж тусгасан байдаг. Хамгийн их бохирдуулагч эх үүсвэрт тооцогдох төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн ойролцоох талбайд хэд хэдэн цэгт Дархан-Уул аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний лабораторид хийсэн шинжилгээний дүнгээс үзвэл агаар дахь азотын давхар исэл /NO<sub>2</sub>/, хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/-н агууламж нь агаар орчны чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулахад нэг удаагийн сорьц дахь бохирдлын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдолгүй байв.

**Гадаргын ус:** Төмөртолгойн уурхайн талбай нь Хараа-Шарын голуудын ай савд орших ба Хэнтийн уулархаг мужийн баруун хойд хэсэгт хамрагдана. Усны гол хагалбарууд болох дунд зэргийн өндөрлөгтэй уул нурууд нь голын хөндийнүүдээс дээш дунджаар 200-400 м өндөрт өргөгдөж жалга, гангаар хэрчигдсэн тогтоцтой. Төмөртолгойн төмрийн ордын тусгай зөвшөөрөл бүхий талбай болон замын зурвас талбайн орчимд гадаргын усны нөөц байхгүй. Унд ахуйн болон уурхайн үйл ажиллагаанд хэрэглэх усыг газар доорх уснаас хангаж байна.

**Газрын доорх ус:** Төмөртолгойн уурхайн геологийн тогтоц нь нүх сүвийн болон ан цавын коллектор болох чулуулаг тархах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн нүх сүвийн ус агуулагч дөрөвдөгч галвын сэвсгэр хурдас нь элсэнцэр, хайрга дайрга, бул чулуу зэргээс тогтоно. Газар доорх ус 30 м-ээс илрэх ба хур тунадасны нэвчилт, ан цавын усаар тэжээгдэнэ. Ундрага 1л/сек орчим байна.

**Усны нөөцийн хомсдол, барагдалт, чанарын өөрчлөлт:** Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар ялган авах тул үйлдвэрлэлийн хэрэгцээнд ус хэрэглэдэггүй.

Талбайн төв хэсэг Төмөртолгойн сайранд малтсан өрөмдмөл худаг нь ан цавархаг метаморф чулуулгийн уст давхаргад нэвтэрсэн.

Уурхайн гүний худгийн усанд ашиглалтын хугацаанд хийгдсэн усны шинжилгээний дүнгүүдээс харвал худгийн ус нь химийн найрлагаараа гидрокарбонатын ангийн, натри калийн бүлгийн, I төрлийн цэнгэг зөөлөн ус байна. Уг усны шинжилсэн бүх үзүүлэлт нь МУ-ын "Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Унд ахуйн

шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ"-ний MNS 900:2005 стандартыг хангаж байгаа тул унд ахуйд хэрэглэхэд тохиромжтой байна.

**Газар хөдлөл:** "Таван үндэс" ХХК хуурай баяжуулах үйлдвэр ба барилгын зураг төслийн инженер геологийн судалгааг хийж гүйцэтгэсэн ба судалгааны талбай нь газар хөдлөлийн 7,2 баллд хамаарна.

**Хөрсөн бүрхэвч:** Төмөртолгойн орд орчмын нутаг нь хөрс газарзүйн муж, био-уур амьсгалын Хангайн их муж, өндрийн бүсжилтэй нутгийн Хэнтийн тойрогт багтана. Төмөртолгойн орд орчмын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг ялгаж тогтооход үндсэн дэд хэв шинжид хамрагдах хөрсүүд тархсан байна. Үүнд :

- Уулын хар хүрэн
- Уулын нимгэн хар хүрэн
- Хөнгөн шавранцар хар хүрэн
- Тариалангийн хар хүрэн
- Нугархаг хар хүрэн зэрэг хөрсүүд шавранцар, хөнгөн шавранцар зонхилсон механик бүрэлдэхүүнтэй байна.

Шинжилгээний дүнгээр эрүүл талбайн хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй үржил шимт чанар ялзмагийн агууламжаар баялаг, ургамал ургахад таатай орчинг бүрдүүлсэн бохирдолгүй байна. Харин нөлөөлөлд өртсөн талбайн хөрс нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ялзмагийн агууламж маш бага, дунд шүлтлэг урвалын орчинтой, үржил шимт чанар багатай хүнд металлын бохирдолгүй байна.

**Ургамлан бүрхэвч:** Ашиглалтын талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал, түүний өөрчлөлтийг доройтлын зэргээр гаргахад уурхайн зориулалтаар газар ашиглалтын явцад ургамлан нөмрөг газрын хөрснөөс арчигдсан хүчтэй доройтсон 18.48%, хог ургамал түрж ургасан дунд зэрэг доройтсон 10.69%, ургац буурсан сул доройтсон 70.83% байна. Тус талбайд бүртгэсэн 73 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 22 зүйл нэг наст өвслөг ургамал (30.14%), 46 зүйл олон наст өвслөг ургамал (63.01%), 5 зүйл мод, сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (6.85%) ургаж байгаагийн дотор 62 зүйл бэлчээрийн (84.93%), 40 зүйл эмийн ашигт ургамал (54.79%) ургахын зэрэгцээ 33 зүйл хөл газрын ба хогийн ургамал (45.21%) ургаж тархац нэмэгдсэн нь тухайн газар ашиглалтын явцад тодорхой хэмжээгээр талхагдалд өртөж доройтож байгааг илэрхийлнэ.

**Амьтны аймаг:** Уурхайн талбай орчмын нутаг дэвсгэр Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалтаар уулархаг Азийн дэд их муж, Монгол Төвдийн мужийн Монгол дагуурын тойрогт хамрагдана. Амьтны аймгийн тархалтын судалгааг хөхтөн, шувуу, шавж гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн бүс нутаг нь хот суурин газарт ойрхон учир амьтны аймгийн томоохон төлөөлөгчид цөөн, сээр нуруугүйтэн амьтад, шувууд дунд зэрэг тархалттай, ядуувтар бүрэлдэхүүнтэй хээрийн бүсийн бодгалиуд тохиолдоно.

**Нийгэм-эдийн засгийн төлөв байдал:**

Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхайн үйл ажиллагаа явагдснаар орон нутгийн төсөвт жилд 6.2 орчим тэрбум төгрөгийн татвар төлөн ажилладаг. Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЗДТГ, ИТХ-тэй хамтран үйл ажиллагааны жил жилийн төлөвлөгөө боловсруулан, харилцан зөвшилцөн батлан ажиллаж, жилийн эцсээр тайланг дүгнэн ажиллаж байна.

### **3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Төмөртолгойн уурхайн үйл ажиллагааны үед агаар, хөрс, ургамал, геологийн тогтоц зэрэгт ихээхэн нөлөөтэй байх боловч цаашдын үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох агаар, хөрс, ургамал болон газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг нөхөн сэргээлт, орчны тохижилт, аюулгүй ажиллагаа зэргийг сайтар төлөвлөн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулбал эерэг тал нь их болох болно.

#### **3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

**Тоосжилтын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө:** Ил уурхайн олборлолт болон баяжуулах үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн зорчих хэсэг, шаардлагагүйгээр удаан хугацаанд асаалттай байх механизм болон ил задгай хаясан хатуу болон шингэн хаягдлаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх нөлөөлөл байж болно. Иймд дээрх асуудлууд дээр анхаарч агаарын чанарыг дээшлүүлэх үйл ажиллагааг менежментийн төлөвлөгөөнд тусган ажиллах болно.

**Тоосжилтын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө:** Тоосны том ширхгүүд (PM10) нь мөгөөрсөн ба гуурсан хоолойн салст бүрхүүлийг цочроож, халдвартай хавсран архаг ринит, ларингит, фарингит, транхет, бронхит үүсгэж болно. Уурхай болон баяжуулах үйлдвэрийн ажилчид ямар ажил гүйцэтгэж байгаа, тоосны найрлага зэргээс хамаарч антропокоз, силикоз, антракосиликоз гэсэн гурван төрлийн уушиг тоосжих өвчин тусч болно. Иймд ажилтнуудад амьсгал хамгаалах хэрэгслийг ажлын үргэлжлэх хугацаанд тогтмол хангаж ажиллана.

#### **3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төмрийн хүдэр ил аргаар олборлохдоо 6 жилийн хугацаанд 150-160м гүнд хүртэл олборлож уулын малталтанд шүүрэн орж ирсэн газар доорх урсацыг зумпээр зайлуулах тул газар доорх усны байгалийн горимд нөлөө үзүүлнэ.
- Уурхайн ахуйн бохир усыг цэвэршүүлэх байгууламж байхгүй. Шууд байгальд нийлүүлсэнээр гүний усанд бохирдлын нөлөө үзүүлэх магадлалтай. Иймд уурхайн ажилтнуудад зориулсан ил жорлонг био жорлонгоор сольж ажиллана.

#### **3.3. Газар болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Тус төслийн талбай нь нийт 494.1 га талбайг хамрах бөгөөд үүнээс уурхайн ашиглалт явагдсан 45.2 га, үйлдвэр, дэд бүтцийн барилга байгууламжийн нөлөөлөлд 26.4 га талбай нөлөөлөлд өртсөн байна.

Төсөл хэрэгжих үеийн хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь:

- ~ Тоосжилтын нөлөөгөөр хөрсний үржил шимт чанар алдагдаж элэгдэл, эвдрэл үүсэх,
- ~ Барилгын суурийн талбайн хөрсөн бүрхэвч дарагдан эвдрэлд өртөх,
- ~ Уурхайн олборлолтын үйл ажиллагаагаар хөрсөн бүрхэвч элэгдэж эвдрэлд өртөх,
- ~ Шатах тослох материал хөрсөнд асгарах зэргээс хөрс бохирдох,
- ~ Тусгай зөвшөөрлийн талбайн гаднах гадаад тээврийн зам, тоосжилтын нөлөөгөөр хөрсний үржил шимт чанар алдагдах,

Хөрсний бохирдол: Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн хатуу, шингэн хог хаягдал, шатах тослох материалаар хөрс бохирдох нөлөөллүүд үүсэж болзошгүй. Шатах тослох

материалаар хөрс бохирдохоос сэргийлж, авто машины зогсоолыг хатуу хучилттай болгох, хөрсөнд бохирдол нэвчихээс сэргийлж хамгаалалтын суурь хийх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг байнга шалгаж, гэмтэл илэрвэл шуурхай арга хэмжээ авна.

Уурхайн үйл ажиллагаа болон түүний хог хаягдал тухайн газрын хөрсөн бүрхэвчинд нөлөөлж байгаа эсэхийг тогтоох зорилгоор хөрсний шинжилгээг авч хүнд металлын шинжилгээг эрх бүхий лабораториор хийлгэнэ.

#### 3.4. Ургамлан нөмрөгийн чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хөрс талхлагдаж, эвдэрч элэгдсэнээр тус ашиглалтын талбайн ургамлан нөмрөг талхлагдаж, ургах нөхцөлгүй болно. Иймд жил бүр уурхайн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх, эдэлбэр газрын тодорхой хэсэгт ногоон байгууламж, тарималжуулалт, орчны тохижилтыг гүйцэтгэн арчлан хамгаална.

#### 3.5 Амьтны аймаг, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн ашиглалт, олборлолт баяжуулалтын үйл ажиллагаа, тээвэрлэлт зэргээс их хэмжээний дуу чимээ, тоосжилт, хүний бөөгнөрөл хөдөлгөөн үүссэнээс амьтны тархац нутаг хумигдах, тоо толгой буурах, хууль бус ан агнуур хийх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.



#### **4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Төмөрголгойн уурхайн үйл ажиллагааны явцад Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБНҮ, байгаль орчны аудит, газрын чанарын хянан баталгаа болон мэргэжлийн хяналтын байгууллага, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын заавар зөвлөмж, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллахад оршино. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- БОНБНҮ-ний заалтуудыг хэрэгжүүлэх,
- “ДТҮ” ХХК-ний байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх,
- БОМТ-г хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох: Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй ААН, байгууллагуудын үйл ажиллагаанд байгаль орчны хяналт тавих,
- Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах зэрэг багтана.

**5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ****5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайн ашиглалт, олборлолтын үйл ажиллагаанд тоосжилт бий болох	Уурхайн дотоод тээвэр, баяжуулалтын хэсэгт тогтмол тоосжилт дарах усалгааны ажлыг гүйцэтгэж их хэмжээгээр тоосжилт үүсэн орчинд тархахаас сэргийлж ажиллах	Уурхайн хэмжээнд	Ширхэг	-	Ус ашиглалтын төлбөрийн дүнгээр тооцно		Үйл ажиллагааны турш	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 MNS 5014:2009 MNS 5013:2009
Тээврийн хэрэгсэлийн яндангаас гарах хорт хийгээр агаар бохирдох	Бүх тээврийн хэрэгсэлийг үзлэг оношлогоонд тогтмол хамруулан засварлах	Уурхайн ашиглалтын тээврийн хэрэгсэлүүд	Удаа	-	Үйл ажиллагааны зардлаар		Жилд 1 удаа	
Тээврийн замын хөдөлгөөнөөс тоосжилт нэмэгдэх	Зам талбайн тоосжилт дарах усалгааг тогтмол хийх. Тээврийн замын дагуу тоос дарах бодис авч ашиглах	Уурхайн гадаад, дотоод зам талбай	л	13	117,000	1,521,000	Дулааны улиралд тогтмол хэрэгжүүлнэ	
Дотоод хяналтгүйгээс агаарын бохирдол ихсэх	Дотоод хяналтын багажаар тогтмол хугацаанд хэмжилт хийснээр тохиромжтой хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулан стандарт хэмжээнд байлгах	Төслийн хэмжээнд	ш	1	Дотоод зардал		Тухайн жилд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
<b>Нийт</b>						<b>1,521,000</b>		

## 5.2. Гадаргын ба газрын доорх усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Усыг хяналтгүй ашигласнаар газрын доорх усны нөөц багасах	Гүний худгийн тоолуурын ажиллагааг тогтмол хянах	Газрын доорх усны нөөц	-	1	Үйл ажиллагааны хүрээнд		Үйл ажиллагааны турш	-Усны тухай хууль -Ус ашиглалт хэрэглээг хянах тоолууржуулах журам MNS BS 8525-1:2015 MNS 4288: 1995 MNS 4047:1988 MNS ISO 5667:2001 MNS 0900:2018
	Ус хэмнэгч хошууг уурхайн ажилчдын ахуйн байрны гар угаах хэсэгт суурилуулах	Ус хэмнэх менежмент	ш	2	50,000	100,000	Жилд 1 удаа	
Гүний худгийн ус бохирдох, газрын доорх ус бохирдох	Худгийн байрны дотор талыг тогтмол цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлт хийж мөөгөнцөр үүсэхээс сэргийлэх	Газрын доорх усны чанар, хөрсөн бүрхэвч, ус хэмнэх менежмент	ш	2	300,000	600,000	Жилд 1 удаа	
	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулж төлбөр төлөх		удаа	1	Төлбөрийн нэхэмжлэхийн дүнгээр		Жилд 1 удаа	
Шүүрлийн усны хэмжилт хийх	Шүүрлийн усны бохирдлын шинжилгээг улирал тутам хийлгэж ус бохирдуулсны төлбөр төлөх	Газрын доорх ус	удаа	12	Төлбөрийн нэхэмжлэхийн дүнгээр		Сар бүр	
<b>Нийт</b>					<b>700,000</b>			

## 5.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрс бохирдох, ургамлан нөмрөг талхлагдах	Хог хаягдал, ариун цэврийн байгууламжийн стандарт шаардлага хангаагүй байдлаас хөрс ургамлан нөмрөг бохирдох, талхлагдах, устах тул бохирын цооногт гэмтэл гарсан эсэхэд хяналт тавих	Уурхайн тосгон	тогтмол	-	Байгаль орчны ажилтан		Сар бүр	<ul style="list-style-type: none"> <li>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,</li> <li>Ургамал хамгааллын тухай хууль,</li> <li>Газрын тухай хууль,</li> <li>Хог хаягдлын тухай хууль</li> <li>MNS 5924:2015, MNS 5344:2011</li> <li>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</li> </ul>
Шагах, тослох материалын хаягдал, алдагдалаар хөрс, ургамал бохирдох	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, засвар үйлчилгээ, ШТС зэргээс шагах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэн зориулалтын талбайд байршуулах, засвар тогтмол хийх	Тээврийн хэрэгслүүд, ШТС, Засварын газар	тогтмол	-	Дотоод зардал		Тогтмол	
Лабораториос химийн бодис алдагдан бохирдол үүсгэх	Химийн бодисын ашиглалт хамгаалалтыг бүртгэлжүүлэн зориулалтын дагуу хадгалах	Лаборатори	тогтмол	-	Дотоод зардал		Жилд 1 удаа	
Ургамлан нөмрөг талхлагдах, зүйлийн бүрэлдэхүүн багасах	Ногоон байгууламж нэмж байгуулах	Уурхайн тосгон	тогтмол		Орчны тохижилт, ногоон байгууламжийн ажлын төлөвлөгөөнд тусгав			
<b>Нийт</b>					-			

## 5.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Газрын хэвлий ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөөгүйгээс болж уурхайн үйл ажиллагаа хаагдах	Газрын хэвлийг ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөх	Уурхайн нийт талбай	424.1 га	Газар ашиглах гэрээний дагуу		-	Газрын хэвлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл
<b>Нийт</b>				<b>Газар ашиглах гэрээний дагуу</b>			

## 5.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хууль бусаар ан агнуур хийх	Ажилчид болон төсөлтэй холбоотойгоор төслийн талбайд ирэх хүмүүст хууль бус ан агнуурын тухай сануулга өгч, хууль тогтоомжийг танилцуулж ан агнуур хийлгэхгүй байх	Уурхайн талбайн орчим	-	-	Дотоод зардал		Тогтмол	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль, MNS 17-5-1-21:1992
Төслийн талбайн ойролцоох ан амьтад хэт их чимээ, хүний хөдөлгөөнөөр дайжих	Төслийн ашиглалтын үйл ажиллагааг өдрийн цагаар гүйцэтгэх, хэт их дуу чимээ гаргах төхөөрөмжүүдийг аль болох зэрэг ажиллуулахгүй байх							
Уурхайн орчимд амьдардаг амьтад идэш тэжээлийн хомсдол орох	Төслийн талбайн хэмжэгээр амьтдын бэлчээр, идэш тэжээлийн талбай хумигдах тул биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх		удаа	1	1,000,000	1,000,000	Өвлийн улиралд	
<b>Нийт</b>					<b>1,000,000</b>			

## 5.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан, тайлагнан батлуулах	Төслийн хэмжээнд	Дотоод зардлаар		Жил бүр	Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль орчны менежмент төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, хянан батлах журам Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль Усны тухай хууль Хог хаягдлын тухай хууль Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Ус ашигласны төлбөр төлөх		Ус ашиглалтын тайлангийн дагуу		Жил бүр	
Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ орон нутгийн ТҮГ-тай хийсэн гэрээний дагуу зайлуулах		Гэрээний дүнгийн дагуу		Тогтмол	
Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан багийн иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд туслах		Дотоод зардлаар		Тогтмол	
Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх		10,000,000	10,000,000		
<b>Нийт</b>			<b>10,000,000</b>		

**6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт	6 р овоолгыг хэлбэршүүлэх	га			69,300,000.0	Жилийн турш	-
Татан буулгах, хаалтад бэлтгэх	Хаалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	-	-	-	Дотоод зардал	Жилийн турш	-
<b>Нийт</b>					<b>69,300,000.0</b>		

**7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төсөл хэрэгжих хугацаанд уул уурхайн нөлөөнд өртсөн газар нутгийн биологийн олон янз байдлын хомсдол орох, алдагдах	Дүйцүүлэн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхээр сонгон авсан газар нутагт техникийн нөхөн сэргээлт хийх	3 га	17,805,000	Жилд 1 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
<b>Нийт</b>			<b>17,805,000</b>		

**8. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нөхөн сэргээлт хийсэн талбайг тэмдэгжүүлэн хамгаалах	Тэмдэг тэмдэглэгээ тавих	Ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч	ширхэг	1	200,000	200,000	MNS 4597: 2014
Төслийн хэмжээнд бичил эко орчин үүсгэх	Цайны газар	Агаарын чанар	ширхэг	100	20,000	2,000,000	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Ойжуулалт хийх	Ой, ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч, агаарын чанар	ширхэг	20,000	Үйл ажиллагааны зардлаар		
<b>Нийт</b>						<b>2,200,000</b>	

**9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уурхайн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт суурьшиж буй иргэд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ явагддаггүй.

**10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төмөртөлгойн уурхайд Улаанбаатар дээд сургуулийн Археологийн тэнхмээр түүх, палентлоги, археологийн судалгаа хийлгэсэн ба уурхайн ажилд өртөх түүх соёлын өвд хамаарах олдвор байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Гэвч уурхайн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвд хамаарах олдвор олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг зогсоож, мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж хамтран ажиллана.

**11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Газар хөдлөлт	Ажилчдын дунд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, мэдээллийн самбар байршуулах	Нийт ажилчид	1	50,000	50,000	Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
	Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	1	Дотоод зардал		Байнга	
Хүчтэй шороон болон цасан шуурга	Гэнэтийн хүчтэй шороон болон цасан шуурга болоход байнгын бэлэн байдалд байж уурхайн талбайд ил задгай замбараагүй тоног төхөөрөмжийг байршуулахгүй байх	Уурхайн хэмжээнд	1	Дотоод зардал		Байнга	
Үер	Уурхайн ам, овоолго, барилга байгууламжийг үерийн усанд автахаас хамгаалах суваг шуудууг хур борооны эрчимжилтэй уялдуулан байгуулах	Уурхайн хэмжээнд	1	Дотоод зардал		Дулааны улиралд	MNS AASHTO 86:2005
Гал түймэр	Болзошгүй галын аюулын үед ашиглах гал унтраах хэрэгсэл, материалыг шаардлагатай газар бэлэн байлгах	Цайны газар, засварын талбай, ШТС	1 багц	1,000,000	1,000,000		
<b>Нийт</b>				<b>1,050,000</b>			



**12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хатуу хог хаягдал	Хонгор сумын ТҮГ-тай “Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	Тогтмол	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр			Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам”
	Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Төслийн хэмжээнд	Улиралд 1 удаа	Дотоод зардал			
	Хог хаягдлын талаар ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх	Ажилчид	Жилд 1 удаа	Дотоод зардал			
	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх	Хатуу хог хаягдлын цэг	Жилд 2 удаа	500,000	1,000,000		
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид ангилан нийлүүлэх	Төслийн хэмжээнд	Тухай бүрт нь	Гэрээний дагуу			
Ахуйн хүнсний хаягдал	Цайны газрын ойролцоо тусгай талбай гарган тохижуулан хүнсний хаягдлаар компост хийх	Цайны газар	Тухай бүрт нь	Дотоод зардлаар			MNS 6507:2015
Аюултай хог хаягдлаар бохирдол үүсэх	ШТМ-ын хаягдал ангилан цуглуулах талбайд төмөр сав бэлдэн хадгалж мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	Төслийн хэмжээнд	Улиралд 1 удаа	Гэрээний дагуу			Аюултай хог хаягдлыг устгах тээвэрлэх түр хадгалах журам
	Засварын талбай, авто зогсоолын талбайд хагарал үүсэж хөрс хүнд металаар бохирдохоос сэргийлж байнгын хяналт хийж талбайг нягталж байх	Засварын талбай, авто зогсоол	Тогтмол	Зардал тусгах шаардлагагүй			
<b>Нийт</b>				<b>1,000,000</b>			

**13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>1. Агаар</b>					
Хорт хийн агууламж Азотын давхар исэл NO <sub>2</sub> , Хүхэрлэг хий SO <sub>2</sub> , Нүүрстөрөгчийн дутуу исэл CO, CH <sub>4</sub>	Ил уурхайн орчим Хөрсний гадаад овоолгын, Баяжуулах үйлдвэрийн орчим ШТС	Жилд 4 удаа, улирал тутам 1	50,000	1,600,000	MNS 4585:2016, MNS 3384:1982, MNS 4048:1988, MNS 5013:2009, MNS 5014:2000
Агаарын гоос, тоосонцор /PM2.5, PM10/	Хаягдлын овоолго Гадаад тээврийн зам Кемпийн талбайн урд Эрүүл талбай				
Дуу чимээ	Ил уурхайн орчим, Баяжуулах үйлдвэрийн орчим 1,2, Кемпийн талбай, Гадаад тээврийн замд				MNS ISO 5128:2005, MNS 6768:2019
<b>2. Усны хяналт шинжилгээ</b>					
Усны химийн шинжилгээ Микроэлементийн шинжилгээ Микробиологийн шинжилгээ	Шүүрлийн ус Шүүрлийн усан сан Малчны худаг	Жилд 2 удаа 5 болон 9 сард	143,500	861,000	MNS ISO 5667-1:2002 MNS ISO 5667-2:2002 MNS 6148:2010
	Гүний худаг Ундны ус	Жилд 4 удаа Улирал тутамд		1,148,000	MNS 0900:2018
	Бохирдуулагч бодис	Бохирын цооног	Жилд 2 удаа 5 болон 9 сард	85,000	170,000
<b>3. Хөрсний хяналт шинжилгээ</b>					
Хөрсний агро химийн үзүүлэлтүүд	Хогийн цэг, Кемпийн талбай, Баяжуулах үйлдвэр, Шимт хөрсний овоолго, Уурхайн ам Дотоод зам дагуу ШТС	Жилд 3 удаа, 5-6, 7-8, 9-10 сард	117,500	1,057,500	MNS 3298:1991, MNS 5850:2019, MNS 3985:1987, MNS 3310:1991, MNS 2305:1995
Хөрсний хүнд элементүүд					
Хөрсний микробиологийн шинжилгээ					

	Эрүүл талбай				
<b>4. Ургамлын хяналт шинжилгээ</b>					
Ургамлын тор тавьж ургамлын бичиглэл хийх	Төслийн талбайн хэмжээнд	Жилд 1 удаа	Дотоод зардал	MNS 6865-1:2020	
<b>Нийт</b>			<b>4,836,500</b>		

Орчны хяналт шинжилгээний дээж цуглуулах байршил, солиболлол

№	х	у	Байршил
<b>Агаар</b>			
1	106°10'0.991"E	49°18'11.032"N	Ил уурхай
2	106°10'56.480"E	49°18'19.207"N	Хөрсний гадаад овоолго,
3	106°10'52.322"E	49°18'34.247"N	Баяжуулах үйлдвэр
4	106°10'44.248"E	49°18'51.774"N	Баяжуулах үйлдвэр
5	106°10'40.444"E	49°18'37.898"N	ШТС
6	106°10'43.856"E	49°18'48.523"N	Хаягдлын овоолго
7	106°10'40.062"E	49°18'33.413"N	Кемпийн талбайн
8	106°10'2.719"E	49°17'43.685"N	Эрүүл талбай
9	106°10'9.559"E	49°18'49.334"N	Гадаад тээврийн зам

№	х	у	Байршил
<b>Хөрс</b>			
1	106°10'43.217"E	49°18'30.553"N	Хогийн цэг
2	106°10'39.478"E	49°18'35.860"N	Засварын газар
3	106°10'44.248"E	49°18'51.774"N	Баяжуулах үйлдвэр,
4	106°10'44.712"E	49°18'41.033"N	Баяжуулах үйлдвэр,
5	106°10'53.908"E	49°18'14.584"N	Шимт хөрсний овоолго,
6	106°10'24.720"E	49°18'18.694"N	Уурхайн ам
7	106°10'45.520"E	49°18'28.207"N	Дотоод зам дагуу
8	106°10'40.444"E	49°18'37.898"N	ШТС
9	106°9'23.617"E	49°18'13.826"N	Эрүүл талбай

№	х	у	Байршил
<b>Ус</b>			
	106° 10' 27.796" E	49° 18' 6.094" N	Шүүрлийн ус
	106° 10' 41.209" E	49° 18' 16.368" N	Шүүрлийн усан сан
	106° 10' 18.802" E	49° 18' 32.918" N	Ундны ус
	106° 11' 12.155" E	49° 18' 52.808" N	Гүний худаг
	106° 8' 28.074" E	49° 18' 23.754" N	Малчны худаг

#### 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Дархан-Уул аймгийн БОАЖ-ын газарт	Хурал	Уурхайн үйл ажиллагаа, 2025 оны БОМТ-ний хэрэгжилт	2025/11	Дотоод зардал	Байгаль орчны инженер	Дархан-Уул аймаг, Дархан сум
Орон нутгийн иргэдэд	Өдөрлөг	Уурхайн үйл ажиллагаа, 2025 оны БОМТ-ний хэрэгжилт, хамтран ажиллах боломжийн талаар сурталчлах	2025/3, 2025/7	1,000,000	Байгаль орчны инженер	Дархан-Уул аймаг, Хонгор сум
БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт	Тайлан, төлөвлөгөө	Уурхайн үйл ажиллагаа, 2025 оны БОМТ-ний хэрэгжилт, 2026 оны БОМТ	2025/10-12	Дотоод зардал	Байгаль орчны инженер	Улаанбаатар хот
<b>Нийт</b>				<b>1,000,000</b>		

#### 15. НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагаа хэрэгжүүлэх хугацаа	Зардал
1	Орон нутгийн олон нийтийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх	Иргэдийн амьдрах орчин мэдлэг ур чадвар сайжрах	Тухай бүрд	1,000,000
2	Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн туслалцаа үзүүлэх		11-1 сард	1,000,000
3	Иргэдийг мэргэшүүлэх сургалтанд хамруулах		Жил бүрийн 3-р улиралд	1,000,000
4	Дүн			3,000,000

**16. ТӨМӨРТОЛГОЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2025 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ**

<b>№</b>	<b>Арга хэмжээ</b>	<b>Зардал, төг</b>
1	Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	<b>13,221,000</b>
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	<b>69,300,000.00</b>
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	<b>17,805,000</b>
4	Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	<b>2,200,000</b>
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	<b>1,050,000</b>
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	<b>1,000,000</b>
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	<b>4,836,500</b>
9	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	<b>1,000,000</b>
10	Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө	<b>3,000,000</b>
<b>Нийт</b>		<b>113,412,500</b>